**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 04 өдөр                Дугаар А/1289                Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авсан нийт 175,400,000.00 (нэг зуун далан таван сая дөрвөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв (З.Балдандугар)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ                                Х.НЯМБААТАР

1110205616

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...11... дугаар сарын 04-ны өдрийн
А/1289 дугаар ...захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

| № | Хөрөнгийн нэр | Марк | Арлын дугаар | Улсын дугаар | Үйлдвэрлэсэн он | Бүртгэх үнэ /төгрөгөөр/ | Эх үүсвэр | Эзэмшигч байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Түргэн тусламжийн автомашин | Hyundai Staria 202404 | KMJYA374BSU185735 | 17-32 УЕН | 2024 | 175,400,000.00 | Дүүргийн төсөв | Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв |
| **Нийт дүн** | | | | | | **175,400,000.00** | | |